

## Эргэн шүүхэд

1990-д оны эхэнд хуучин тогтолцоо нуран унаж, худалдан авах чадварынхаа 67 хувийг бараг ганцхан шөнийн дотор алдсан Монголын ард иргэдийн амьдрал ахуй туйлын хүнд болсон билээ. Энэ сүйрэлээс гарах “road map” буюу “Замын зураг” байхгүй байлаа. Энэ сүйрэлээс хөтлөөд гаргах арга замыг мэддэг боловсон хүчин, шинэ тогтолцоонд шилжүүлэх үйл явцыг гардаад удирдаад явах институтци хараахан алга байв.

Ямархүү нөхцөл байдал үүсээд буйг нэг талаас, нөгөө талаас - “Бор гэртээ Богд, хар гэртээ Хаан байх” хэдэн зуун жилийн хүсэл нь биелэх цаг ирж буйг зөн совингоор мэдэрсэн монголчуудын дийлэнх нь “...Бид тэвчинэ, харин та нар тэр өөрчлөлт шилжилтээ тууштай хийгээрэй” гэж Ардын Их, Бага Хурал, Засгийн газартаа захиж, тал бүрээр дэмжиж байсан билээ. Хуучин цаг, эрх мэдлээ хадгалах хүсэлтэй хүч нөлөө бүхий нэг хэсэг нь өөрчлөлт шилжилтийг жадлан эсэргүүцэж, саад тотгор учруулж, өөрчлөлт шилжилтийн аливаа алхамыг гутаан доромжлох, бойкотлах, алхаа гишгээ бүрийг үгүйсгэх, алдаа бүрийг нь сэвэн дэвэргэх ухуулга суртачилгаа ил далд явуулж байлаа.

Нэг талаас “road map”-гүй, мэдэхгүй, чадахгүйн зовлон, нөгөө талаас өөрчлөлт шинэчлэлтийн аливаа бодлого шийдвэр, алхам бүрийг нь жадлан эсэргүйцэж буй хуучинсаг хүчний (гадныханы удирдамжийг дагасан) эрээ цээргүй эсэргүйцэл бүхий тэр нөхцөлд монголоо аврах ёстой байлаа. Үнэндээ, тухайн үед нийгэм улс төрийн болон эдийн засгийн гэсэн хос өөрчлөлтийг хослуулан, нэгэн зэрэг хийхээс өөр сонголт байгаагүй учраас нийгэмд зөвшилцөл үүсгэх бодит шаардлага буй болсон юм.

Мэдэхгүй чадахгүйн зовлонтой учирсан эрх баригч нар шинээр бүрэлдэж буй улстөрийн хүчинд хандах, тэднээс боловсон хүчний болон үзэл баримтлал, бодлогын дэмжлэг авахаас өөр аргагүй байв. Шинэ улс төрийн хүчин нь ямар том трансформациатай учирч байгаагаа, тэндээс гарах ямар шийдэл байхыг бүрэн мэдэхгүй байсан хэдий ч залуу насны “айхыг мэдэхгүй” эр зориг, эрч хүчээр дүүрэн оргилуун, халуун эх орон ч сэтгэлдээ хөтлөгдөн “Ардчилал ба Зах зээл” хэмээх ёроолгүй далай руу шумбан орсон юм.

Нэгэнт нүдэн дээр илт нуран унаж буй, “түймэрт автагдсан гэрээс” чадвал ганц нэг, бүрэн бүтэн, хэрэгцээт юм аа авч үлдэх гэж буй бол ямар нэгэн үйлдэл хийх ёстой болохоос, төлөвлөөд л яах ийхийг бодоод байх цаг хугацаа үгүй байжээ. Тэгээд ч голын эрэг дээр мянган дасгал хийсэн ч, гол усандаа орж баймаааж л сэлж сурна, тиймээс тэр ардчилал, зах зээл гэдэг рүү эртхэн орох нь зөв, “Зовлонгийн хурдан жаргалын удаан” гэж хос өөрчлөлтийг хэрэгжүүлж эхэлсэн юм.

Эхэндээ улс төрийн шинэчлэл нь харьцангуй хурдан өрнөж эдийн засгийн шинэчлэл нь хоцорч байлаа. Гэсэн хэдий ч ёстой л алдаж онож байж олсон эдийн засгийн шийдэлүүд нь хоёрхон жилийн дотор дэлгүүрийн лангууг бараа товаараар дүүргэж хомсдол гэдгийг нүд ирмэх зуур үгүй болгосон юм. Энэ үед л хэрэглээг “шүтсэн” нийгмийн эхлэл тавигдсан бөгөөд “таваарын фитишизм” нь олны нүдийг, ялангуяа эрхтэн дарга нарын нүдийг бүрхэж, хүний төрөлхийн шунал нь илэрч, өнөөгийн нийгмийг бүрэн торлосон авилга газар авч эхэлсэн юм.

90 оны үйл явц нь феодализмаас капитализмыг алгасан социализм цогцлоогчийн үлгэр жишээ гэгдэж байсан зөвхөн монголын биш, тухайн үедээ ганхахгүй мөнх гэж байсан ЗСБНХУ-ыг 15 болгон задруулан, социалист системийг бүхэлд нь нурааж, капитализм, либерал үзэл суртлын төгс ялалтаар өндөрлөж байв. Ф. Фукуяма 1989 онд “...Түүхийн төгсгөл ирлээ” гэж бичиж байсан бөгөөд түүний дүгнэлтийг тив дэлхийн дийлэнхи судлаачид хүлээн зөвшөөрч байлаа. Цаашид бидний замнал нь “Улс төр, эдийн засгийн либерализм” гэдгийг шилжилтийн эдийн засагтай улс орнууд бүгд хүлээн зөвшөөрсөн юм.

Ингэж хүлээн зөвшөөрөх нь бас аргагүй байсан. Бүх төрлийн абсолют засаглал, фашизм, социализм, коммунизмаас залхаж туйлдсан, өнгө мөнгөнд шахагдаад хуулийг үзээгүй, дарангуйлалд хамаг насаа өнгөрүүлсэн ард олон засаглалын өөр хэлбэрийг хүсэж байсан бөгөөд нь тэр нь “Ардчилал” байв. Ардчилалын ямар нэгэн дурсамж, ой санамж, туршлага ч үгүй улс орнуудад хүртэл “Ардчилал” үйлчлэнэ гэж бүгд итгэж байв.

Ард түмний дуу хоолой санал бодол нь жинхэнэ ёсоор төрд хүрч, тэд эрх чөлөөгөө шаардаж эдлэж эхлэхэд ямар ч дарангуйлагч тэсэхгүй, “Ардчилал”-ыг хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй гэж ойлгож байв.

“Ардчилал” нь иргэдийн эрх, эрх чөлөөг хангаж, эдийн засгийн өсөлтийг өгч, олны дуу хоолойг ямар нэгэн байдлаар сонсдог төр засаг бүрдүүлдэх учиртай хэдий ч явц дундаа доголддог гэдгийг тооцсон нь хэд билээ. Ардчилсан механизмаар дамжуулан дандаа зөв зүйтэй шийдвэр гаргана гэсэн баталгаа байхгүй гэдгийг, “Ард түмэн дандаа зөв, ард түмэн хаан сонголт хийдэг...” гэх мэтийн уянгын мөрөөдөлтэй шинэчлэгчид мэдээгүй юм.

Тогтсон үхширмэл үзэл баримтлалдаа дөнгөдүүлсэн, “улаан хамгаалагч” нэг хэсэг сонгогч, дөжирсөн, юу ч тоодоггүй, сонирхдоггүй, цаг нь болохоор саналаа худалддаг нэг хэсэг хамтдаа бидний ирээдүйг тодорхойлдог болно гэж тооцсон мэргэн ховор байлаа.

“Бо” болон МАХН түүхийг судалсан цөөн хэсэг сэхээтнүүд тэрхүү шилжилт нь дардан замаар өрнөхгүй, М.Тэтчер авхайн хэлсэнээр “Ядаж хоёр үе солигдож байж” цэгцрэх байх гэдгийг сонсож байсан билээ.

Хуучин социалист орнуудад болж байсан \Албани улсад иргэд нь гудамжинд их буу гарган байлдаж байсан\ хувьсгалын эсэргүйцэл, орой бусгай байдал зэргийг монголчууд “Хулганы хамраас цус гаргалгүй” харьцангуй тайван замаар өрнүүлсэн нь бахархал юм.

Улс төрийн ардчилал бидэнд үлдэж буй цорын ганц сонголт гэдгийг хүлээн зөвшөөрөхдөө ардчилал нь эдийн засгийн өсөлтийн функци бөгөөд улс орны эдийн засаг хөгжиж, ард иргэд, улс орон баяжих хирээр дарангуйлагч дэглэмрүү буцахгүй гэж итгэж байлаа. Мөн ардчилсан улс орнууд хоорондоо дайн өдөөхгүй учраас даян дэлхийд энх тайван тогтоно гэсэн үзэл санаанд итгэж явсан билээ.

Эдийн засгийн либерализмын хувьд ч ойлголт тун өөдрөг байсан юм. “Чөлөөт зах зээл л аврал...” гэж зөвхөн Монгол төдийгүй хуучин социалист орнууд, бүгд л тэгж үзэж байв. Учир нь зах зээлийн эдийн засагтай улс орнууд бүгд л төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас илт давсан үзүүлэлттэй байсан. Хамгийн энгийн жишээ болгон Өмнөд ба Хойт Солонгос, Зүүн ба Баруун Германы эдийн засаг, нийгмийн үзүүлэлтүүдийг гаргаж тавидаг байв.

Зах зээлийн тогтолцоо нь ард иргэдэд хүссэн ажил үйлчилгээ, бараа таваарыг санал болгож, бүх салбарт инноваци буюу шинэ, шинэлэг шийдэл хөхийлэн дэмжиж, нийгмийн хөгжлийг хангаж байгаа нь илт байв. Тиймээс эдийн засгийг либералчлах дөрвөн чиглэлд \Өмч хувьчлал, үнэ, гадаад дотоод худалдаа, ханш либералчлах\ онцгой анхаарч байлаа.

Төрийн зохицуулалт нь хуучин захиргаадалттай утга нэг ойлгогдож байжээ. Ардчилал ба зах зээлийг сонгож, тэдгээрийг залах чиглүүлэх үндсэн хэрэгсэлүүдийг буй болгож, 90 оны тэр аймшигт сүйрэлээс Монголоо богино хугацаанд гаргаж, монголчууд өмч хөрөнгөтөй болж, эрх чөлөөг эдлэн амьдрах шаардлагатай нөхцөл бүрдүүлсэн нь бидний хамтын ололт амжилт юм. Гэсэн хэдий ч 90-д онд хэрэгжүүлсэн бодлого арга хэмжээ нь зөвхөн “шаардлагатай” нөхцөлийг бүрдүүлсэн бөгөөд “хангалттай” нөхцөл нь хаана ч юм, яаж ч юм орхигдсон байжээ.

Улс төр, эдийн засгийн либерализм 33 жилийн дараа ад үзэгдэж, ардчилал зах зээл хараалын үг болж, дарангуйлал илт цухалзаж, үзэл бодлоо илэхийлсэн иргэдээ шоронд хаддаг болж, төрийн алба, оролцоо нь геометрийн прогрессоор өсөж, авилга хүнд суртал нь нийгмээрээ хүлээн зөвшөөрөгдсөн үзэгдэл болж, өмчийн эрхийг эрх дархтанууд илт хөсөрдүүлэн, хүчтэй, эрх мэдэлтэй нэгэн нь бусдыгаа илт дээрэмдэж, дээрэмдүүлэхгүйн тулд бизнесийнхэн төрд “хүнээ шахдаг” болж, орлогын ялгарал эрс нэмэгдэж, буцаад төвлөрсөн төлөвлөгөөт мэт эдийн засаг дэх төрийн оролцоо хүчээ авч буйг анзаарахгүй байх аргагүй боллоо.

Ардчилал ард олны, ялангуяа залуусын хүсэн хүлээж буйг өгч чадахгүй байгаа учраас баруун, зүүний хэт туйлширсан үзэл газар авч байна. Өмч хөрөнгөтөй хүмүүсийг үзэн ядах байдлаар нийгмийн бухимдал илэрч, социализмын ой санамжгүй залуус түүнийг магтан дуулж, тэгшитгэн хуваарилах үзэл санааг популистууд дэвэргэж буй өнөөгийн нөхцөлд, төрийн төлөө зүтгэх үүрэгтэй сонгогдсон 76 нь Үндсэн хуулийг өөрчлөх замаар эрх мэдэлтэйгээ үлдэх арга замаа хайж байна.

Ардчилал зах зээлийг эрхэмлэсэн парадигм арчигдаж, оюун санааны аюултай шилжилт нь өрнөж байна. Эдийн засгийн хөгжил, ард иргэдэд хүртээмжтэй боловсрол эрүүл мэнд, халамжийн үйлчилгээг ардчилсан тогтолцоо нь илүү хүргэдэг гэдгийг эрдэм шинжилгээний судалгаа шинжилгээ илт нотлоод байхад яагаад суурь үзэл санааруугаа дайраад байна аа?

Ардчилалгүй Хятад болоод байгаа биз дээ? гэж ярьдаг. Тиймээ, БНХАУ эдийн засгийн реформ оо 1978 онд зуугуйхан эхэлсэн бөгөөд тэр үед перестройка, гласностиин сураг ч байгаагүй. Бид 90 онд, аянга нэргэсэн хойно нь, бүх юм нурсан сүйрсэн хойно нь реформыг эхэлсэн. Улс Төрийн Товчоог бүрэн бүрэлдэхүүнээр нь огцруулсан МАХН-ын 90 оны бүгд хурал дээр үг хэлсэн болгон “өөрчлөн байгуулалтыг залж чадсангүй, хугацаа алдсан” гэж нэгэн дуугаар дүгнэж байсан. Хамаг муу муухай нь давхацсан, нийгэм, эдийн засаг бүхэлдээ хямралд нэгэнт орчихсон хойно зугуухан тайван реформ хийх боломж үгүй байсан юм.

## Тэгээд яах билээ

Ардчилал өөрөө тасралтгүй тордолт асаргаа шаарддаг юм аа гэдгийг одоо л ухаарахгүй бол, эрх мэдлээ алдсан 90 оны өмнөх элит, дараа нь гарч ирсэн олигархиуд доголлон, дүр эсгэсэн ардчилалыг тасралтгүй тэтгэх нь илт байна. Нөгөө талаас, ардчилсан Монголыг хүсэж буй гадаад орчин ч юу билээ гэж бодох ёстой.

Ардчилсан засаглал нь байнгын нөр их тэвчээр, хүч чармайлт шаардсан зөвшилцөлийг үгүйдэг. Зөвшилцөөд байна гээд л хамаг цаг заваа дэмий үрж байгаа мэт санагдаж тэр бүгдийг захиргаадгалтын аргаар шийдээд явья гэсэн Ерөнхий сайд нарын эрмэлзэлийг ойлгож болох ч энэхүү арга нь эцэстээ шийдэл биш харин “Асуудал” болдог гэдгийг ухаарах ёстой.

Ардчилал нь хэн дуртай нь эдэлж хэрэглэдэг зүйл биш бололтой. Мэдлэг боловсролтой, ялангуяа улс төрийн зохих боловсролтой, шүүмжит сэтгэлгээтэй иргэн л ардчилалыг бэхжүүлнэ. Тухайлбал, нийгмийн сүлжээ хоёр үзүүртэй зэвсэг бөгөөд ардчилалыг бэхжүүлэх, хөнөөх аль алинд ашиглаж болдог юм гэдгийг ялган салгаж, хэзээ хаана яаж ашиглах аа мэддэг иргэн төлөвшүүлэх ажлыг орхигдуулмааргүй байна.

Нийгмийн 1/3 нь ядуу, дундаж давхрага нь нүдэн дээр илт ширгэж, хамгийн их ажил олгогч нь төр болсон нөхцөлд зах зээлийг үгүйсгэж харлуулах нь ойлгомжтой бөгөөд гунигтай. Асуудал нь зах зээлдээ байгаа юм биш харин түүнийг зөв залж чиглүүлж чадахгүй буй Засагт л байгаа юм. Залж чиглүүлж чадахгүй байгаа Засгийн цаана нь эрх мэдэлд шуналтсан, эрх мэдлээр завших, баяжих хүслээ хязгаарлаж чаддаггүй, өсөхийн өлсгөлөнд автсан хэсэг бүлэг зальт луйварчин этгээд байгаа юм. Тэд л бусдын ядуу эмзэг, хараат байдлыг далимдуулан улс төрийн намын толгойд гарч, нам гэдэг халхавчин дор Төрөөр, Засгаар тоглож байна.

Өнгөрсөн 33 жилийн алдаа оноог дэнслэн нийгэм эдийн засгийн хөгжлийн чиг хандлага, хэрэгжүүлэх бодлого, арга механизмын талаар хамтын чармайлтаар шинэ парадигм дэвшүүлэх цаг боллоо.

1. Нүдэнд илт харагдаж байгаа нэгэн зүйл бол ардчилалыг хэн ч өмчлөх эрхгүй, хамтын бүтээл, нийт ард олны зүтгэл чармайлтын үр дүн, хүсэл эрмэлзлэлийн оргил гэж бүгд хүлээн зөвшөөрөх явдал билээ. АН аас бусад нь ардчилалын эсрэг, шүүмжлэгч маягаар өдий хүртэл нийгмийн ухамсарыг бүрдүүлж байсан нь том алдаа бөгөөд “өсөхийн”, “нялхсын өвчинд” үе үе автагддаг Ардчилсан Намыг ардчилалтай ижилсүйлэн ойлгож байгаа нь нийгэмд хортой юм.
2. Давуу тал нь ойлгомжтой, хүлээн зөвшөөрч болохуйц хэдий ч ардчилал нь дарангуйлалыг ямарч болсон ойрын үед даван дийлэхгүй юм. Тодорхой орчин нөхцөлд ардчилал нь дарангуйлалыг өөгшүүлэн, нийгмийн ухамсарыг дарангуйлал руу хөтлөж байна.
3. Ардчилал нь хаа сайгүй ургадаг зэрлэг хогийн ургамал биш, харин онцгой нөхцөл, нөр их хүчин чармайлт шаардсан феномен учраас технологийн дэвшил, глобальчлалын сөрөг дайвар нөлөөлөл, орлого болон статусын ялгарал зэрэг нь ардчилалыг хумиж, хөгжин дэвших үйлэн цоорхойг хумиж байна. Ардчилал цэгцэглэн дэлгэрэх боломж улам л ширгэж байгаа учраас түүнийг арчилахад өмнөх өмнөхөөсөө илүү их хүч чармайлт хэрэгтэй.
4. Нийгмийн амьдрал нарийн төвөгтэй, түүнийг механик аргаар (сонгуулийн хуулийг өөрчлөөд гэх мэт) шийднэ гэдэг нь эндүүрэл. Технологи нь, ялангуяа сонгуулийн технологи нь ардчилсан институтыг үгүйсгэж, олны тархийг угааж, дарангуйлагч, популист нарын шидэт зэвсэг болдог гэдгийг бид тод харж байна. Ялангуяа нийгмийн сүлжээ нь төрийн бүх институтыг орлон, шинэ үеийнхэний тархийг базаж буй нь чухам юунд хүргэх, эдгээр технологийг хэрхэн зохицуулах нь ойлгомжгүй, тодорхойгүй байгааг анзаарахгүй өнгөрч болохгүй.
5. Ардчилалыг тухайн улс доторхи л асуудал гээд гадаад орчныг орхигдуулах нь маш том алдаа. Манай нийгмийн сүлжээнд гаднаас халдан, тодорхой зорилготой орон зайгаа эзэлсэн троллерууд яаж сүйтгэж байгааг бид гэрчлэнэ. Эндээс үүдэн автократ тогтолцоотой улс гүрнүүдтэй чухам ямар харилцаатай байх, ардчилалын үнэт зүйлээ худалдчихгүй байх зэрэг туйлын ярвигтай сонголт, шийдэл, сорилт биднийг хүлээж байна.
6. Глобаль ертөнцөд ялангуяа манайх шиг далайд гарцгүй улс орны хувьд гадаад харилцаа, гадаад эдийн засгийн харилцаа төвөгтэй түмэн сорилт дэвшүүлэх нь ойлгомжтой бөгөөд эл нөхцөлд завшаанчдад олзлогдохгүй, гадаад харилцааг хэн нэгэн субъектын өмч болгохгүй байх нь онцгой чухал.
7. Эдийн засгийн гайхамшигтай өсөлт байлаа ч түүнээс бүгд хүртэж чаддаггүй, боломжгүй юм байна. Технологийн хөгжил, хөдөлмөрийн бүтээмжийн өсөлт зэрэг урьд өмнө байгаагүй эдийн засгийн өсөлт тэлэлт буй болгосон хэдий ч, сурах бичгээр бол хөдөлмөрийн бүтээмж нь цалин хөлсийг өсгөн нэмэгдүүлнэ гэдэг хэдий ч амьдрал дээр илэрэхгүй л байна.
8. Хөдөлмөрийн бүтээмжийн өсөлтийг хангаж буй хүчин зүйл чухал хэдий нийгмийн баялагийн хуваарилалт, ялангуяа татвар, цалин хөлсөөр дамжуулан хэрэгжүүлж буй баялагийн албан ёсны дахин хуваарилалт нь дээрхээс илүү чухал юм байна. Авилга, илт хулгай, эрх мэдэл албан тушаалаар зэргээр нийгмийн баялагийг албан бус (далд эдийн засаг) байдлаар дахин хуваарилах нь тун аюултай. Ганц жишээ татахад бүтээмжийн өсөлт нь IT-ийн хэд дээр тусаад бусдад хүртээлгүй байгаа учир шалтгаан нь технологи дэвшил, төрийн бодлого болон нийгмийн хүлээн зөвшөөрөгдсөн хэм хэмжээ зөв уялдуулж, зохих тэнцвэрийг хангаж чадахгүй байгаатай холбоотой.
9. Зах зээлд улс төрийн бодлого шууд нөлөөлдөг. Харин тэр улс төрийн бодлого нь тухайн улсынхаа хөгжлийн хүрсэн түвшинг харгалзсан хийгээд урагшлах зам, хөдөлгөгч хүч зэргийг зөв

тодорхойлсон байх ёстой юм. Мунхаг миний бодлоор манай улсын эдийн засаг-нийгэм, улс төрийн харилцаа нь сонгодог капитализмын дүр төрхийг олох гэж чармайж буй ч балар эртний нийгэм эдийн засгийн харилцаанаасаа (боол, феодал, социализм, капиталын хуримтлалын үеийн капитализм зэрэг) огтхон салж чадаагүй яваа билээ. Социалист байгуулалтын он жилүүдэд олигтойхон ажилчин анги буй болгож чадаагүй жишээ дурьдаж болно. Тиймээс эдгээр олон давхрагат харилцаа, тэдгээрийн онцлог зэргийг тусгасан эдийн засгийн бодлого, үйл ажиллагаа явуулах ёстой.

Түүнээс гадна глобаль худалдаа арилжаа, нийлүүлэлтийн гинжин хэлхээс, өрсөлдөөн зэргийн агуулга хэлбэрийг технологийн дэвшил, нэн ялангуяа дижитал харилцаа холбоо, хиймэл оюун ухаан тодорхойлж байгааг нэгэнт нээлттэй эдийн засаг болж буй монгол соргог анзаарч, тэр процесс нь ямар боломж ба сорилтыг бидний өмнө тулгаж байгааг нягталж байх учиртай.

Бодлогын тууштай, тогтвортой байдал онц чухал бөгөөд урт хугацааны хөрөнгө оруулалт, эдийн засгийн хөгжилд шууд нөлөөлж байна. Бодлогын залгамж чанар, тогтвортой тууштай байдал нь тодорхой бус байдлыг бууруулж, тасралтгүй хувьсан өөрчлөгдөж буй нөхцөлд цаг алдалгүй, алхам алхам өөрчлөлт, хариу үйлдэл хийх боломж олгоно.

Эзэд нь өөрсдөө ч ойлгохгүй тунхаглаж буй үзэл суртлын хэнээрхэл, улс төрийн тогтворгүй байдлаас үүдэлтэй бодлогын тогтворгүй байдал нь хөрөнгө оруулалтыг бууруулж, өсөлтийг доройтуулж, алдагдсан боломжийн асар өндөр өртөг нэхэж байна.

Тиймээс хэрэгтэй хэрэггүй хагарал бутрал, талцлаас давсан нийтлэг ашиг сонирхол, үзэл бодлыг олж тогтоох, ахар хугацаанд ашиг хонжоо хайхын оронд нийтлэг талыг арчлан тордохыг цаг үе шаардаж байна.

-o-O-o-

Эндээс үүдэн зах зээлийн тухай ойлголтоо цэгцлэх шаардлагатай. Зах зээлийн зөв сигнал, түүний үүсгэж буй сэдэц мотиваци нь инновацийн эрэлхийлэлийг дэлгэрүүлэн эцсийн дүндээ та бидний эрүүл энх тунх байдал, дундаж наслалт нэмэгдэж буй, ая тухтай амар тайван амьдрал бүрэлдэх нөхцөл болсон. Зах зээл инновацийг үнэхээр дүрэлзүүлж байгаа хэдий ч нийгмийн чанартай “бүтээгдэхүүн” хангалттай “үйлдвэрлэж” чадахгүй байна.

Зах зээл ашиг өндөр чиглэлийг тун шуурхай тодруулан, хөрөнгө оруулалт, авьяас, мэдлэг ур чадварыг төвлөрүүлэн чиглүүлж байгаа. Гэхдээ нийгмийн ач тус нь бас зэрэгцэн мэдрэгдэхүйц байхаар зах зээл ажиллаж чадахгүй байна. Нийгмийн халамж, ач тусыг хангах үүрэг хүлээж, амлалт зах зээл өгөөгүй, өгдөггүй. Зах зээлээс илүү дутуу юм шаардах хэрэггүй.

Нөгөө талаас нийгмийн гишүүд нь эдийн засгийн өсөлт тэлэлтийн үр шимийг бас давхар мэдэрч хүртэж байхгүй бол нийгмийн, баян хоосоны, өмчтөй өмчгүйн ялгарал туйлдаа хүрнэ. Туйлширсан нийгэм гадаад нөлөө, тоглоомд хялбар өртөх бөгөөд хамгийн өөдрөгөөр төсөөлбөл “Иргэний дайн бүхий нийгмийн хувьсгал”-аар дуусна. Жишээ нь, хүн бүрийн “сайн мэддэг” эмнэлэгийн үйлчилгээ, эрүүл мэндийн салбар дэлхийд төдийгүй монголд тун ашигтай бизнес учраас өндөр технологи бүхий эрүүл мэндийн нэгжүүд буй болж байна. Гэхдээ, нийтийн эрүүл мэндийн инновацид оруулж буй хөрөнгө оруулалт, түүний ашиг, үр өгөөж нь бидний эрэлтийг хангахгүй байна. Өөр нэг жишээ, түмэн олны дарамт шахалт, төрийн дэмжлэггүй “ногоон хөгжил” хөдлөхгүй нь илт.

Нийгмийн чанартай төсөл, хөтөлбөрт бүх төрлийн хөрөнгө оруулалтыг чиглүүлэх ямар механизм байхыг Засаг манлайлан эрэлхийлэх ёстой. Тухайлбал, шилжүүлэг, татаас маягаар нийгмийн халамжийг хангах уламжлалт ойлголтийг ч эргэж хармаар юм. Зах зээл мөчлөгтөй, үе үе “бүтэлгүйтдэг” гэдгийг бид мэддэг болсон. Тиймээс элдэв бүтэлгүйтлээс даатгасан төрөл бүрийн ирээдүйн өв сан байгуулах нь нэн чухал билээ. Зөвхөн татвараар нэгээс нөгөөд шилжүүлэх, дахин хуваарилах замаар асуудлыг шийддэг үе нэгэнт өнгөрсөн.

“Road map”-гүй танихгүй газар хэцүү л байдаг. Ерэн оны эхэнд бид “Замын зураг”-гүй том аян эхлүүлсэн, нилээн ч урагшилсан. Гэхдээ одоо бидний туулах зам бүр л хол бөгөөд мөн л аян замын зураг нь бэлэн болоогүй байна даа.